



ТЭЭВЭР ХӨГЖЛИЙН БАНКНЫ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН Т.БАТМАГНАЙ 2023 ОНЫ 2 ДУГААР УЛИРЛЫН АЖЛЫН ТАЙЛАН

Тээвэр хөгжлийн банкны Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолоор Т.Батмагнай миний бие 2023 оны 1 дүгээр сарын 02-ны өдрөөс ТУЗ-ийн хараат бус гишүүнээр томилогдон ажиллаж байна. ТУЗ-ийн хараат бус гишүүний хувьд Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа “Компанийн тухай хууль”, “Банкны тухай хууль” болон Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар батлагдсан “Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журам”, “Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журам”, “Тээвэр хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам” зэргийг тус тус хэрэгжүүлэн ажилласан болно.

1. ТУЗ-ийн хуралд оролцсон байдал:

2023 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрийг хүртэлх хугацаанд Төлөөлөн удирдах зөвлөлийн нийт 2 хурал зарлагдснаас хараат бус гишүүний хувьд бүх хуралд 100% ирцтэйгээр асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэхэд саналын эрхтэй оролцсон байна. Үүнд:

1. Банкны ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд хавсралт ёсоор нэмэлт өөрчлөлт оруулан шинэчлэн батлахаар шийдвэрлэв.
2. Банкны ТУЗ-ийн дэргэдэх эрсдэлийн удирдлагын хорооны журмыг шинэчлэн хавсралтаар батлахаар шийдвэрлэв.
3. Банкны 2022 оны Хөндлөнгийн аудитын тайлантай танилцаж холбогдох журмын дагуу тус тайланг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар буюу 2023 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж батлуулахаар шийдвэрлэв.
4. Ногдол ашиг хуваарилах эсэх талаарх асуудлыг хэлэлцэн банк нь 2023 онд ногдол ашиг хуваарилахгүйгээр санал гаргаж тус асуудлыг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлэн батлуулахаар шийдвэрлэв.
5. Тээвэр хөгжлийн банкны Тогтворжуулах төлөвлөгөөг хавсралт ёсоор батлав
6. Банкны Гүйцэтгэх удирдлагын багийн ажлын тайлантай танилцав

7. Банкны 2022 оны үйл ажиллагааны тайлантай танилцаж тус тайланг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулахаар шийдвэрлэв
8. Банкны Ёс зүйн дүрмийг хавсралт ёсоор шинэчлэн батлав
9. Банкны Мэдээллийн аюулгүй байдлын бодлогыг хавсралт ёсоор шинэчлэн батлав
10. БНХАУ-д банкны Хятад улс дахь Төлөөлөгчийн газар байгуулахыг зөвшөөрч, төлөөлөгчийн газар байгуулахтай холбоотой зардал төсвийг хавсралтаар батлав
11. Банкны Тогтворжуулах төлөвлөгөөнд хавсралт ёсоор нэмэлт өөрчлөлт оруулан шинэчлэн батлав

ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны хуралд ажилласан тухай:

Аудитын хороо нь 2023 оны 2 улиралд 1 удаа буюу 2023 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр хуралдаж дараах асуудлыг хэлэлцсэн. Үүнд:

1. Дотоод аудитын газраас өгсөн зөвлөмж, үүрэг даалгаварын биелэлтийн байдал
2. Дотоод аудитын газраас хууль эрх зүйн газарт хийсэн аудитын тайлангийн тухай

Аудитын хорооны хурлаас дараах санал дүгнэлтийг гаргасан болно. Үүнд:

1. Дотоод аудитын газраас Гүйцэтгэх удирдлагад өгч буй зөвлөмжийн биелэлтийн байдлыг цаашид тодорхой давтамжтай ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороонд танилцуулж байхыг үүрэг болгов
2. Хууль эрх зүйн газарт хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, өгсөн зөвлөмжийг заасан хугацаанд хэрэгжүүлж ажиллах талаар хууль эрх зүйн газрын захиралд анхааруулга үүрэг өгөв

Тайлан бичсэн:

ТУЗ-ийн хараат бус гишүүн:



Т.БАТМАГНАЙ